



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн  
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	10
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 37  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

15 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Л.ГЭЛЭГМАА ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

15 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>92002466.84</u></b>	<b><u>85097165.52</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	51258.00	51258.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа мөнгө</b>	51258.00	51258.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>91,951,208.84</b>	<b>85,045,907.52</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	84728608.84	84252837.52
35110	Тусгай зориулалттай материал	84728608.84	84252837.52
354	Хангамжийн материал	7222600.00	793070.00
3542	Аж ахуйн материал	4655100.00	704710.00
3546	Хүнсний материал	2567500.00	88360.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1942318832.85</u></b>	<b><u>1892351967.17</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1942318832.85	1892351967.17
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1514308832.93	1464451967.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1568266950.03	1580963950.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(95385348.58)	(150877276.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45343463.15	48208963.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(-20109399.05)	(27418587.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57082719.32	57662719.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40889551.94)	(44087801.20)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	428009999.92	427899999.88
39301	Программ хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(220000.08)	(330000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	427680000	427680000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2034321299.69</u></b>	<b><u>1977449132.69</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2034321299.69</u></b>	<b><u>1977449132.69</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2034321299.69</b>	<b>1977449132.69</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1131055744.00	1131055744.00
51101	Өмч: - төрийн	703375744.00	703375744.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(76949650.80)	(133821817.80)
51210	Өмнөх үеийн үр дүн	(47153384.62)	(76949650.80)
51220	Тайлант үеийн үр дүн	(29796266.18)	(56872167.00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	980215206.49	980215206.49
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2034321299.69</u></b>	<b><u>1977449132.69</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>731553553481.00</b>	<b>689274400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>59115081.00</b>	<b>18607000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	59115081.00	18607000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59115081.00	18607000.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59115081.00	18607000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>983,111,100.00</b>	<b>1,008,149,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	615807600.00	611527900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	615807600.00	611527900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>1530000.00</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		200000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		700000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого		630000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		57609500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсвөөс/		59607500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>761349747.18</b>	<b>746146567.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>761349747.18</b>	<b>746146567.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>738577778.18</b>	<b>724825361.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>487898200.00</b>	<b>503585311.00</b>
210101	Үндсэн цалин	357678920.00	367647398.00
210102	Нэмэгдэл	92293598.00	96754152.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1119200.00	1201600.00
210104	Урамшуулал	36806482.00	37982161.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62052594.00</b>	<b>66746406.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	42705117.00	47046061.00
210202	Тэтгэмжийн даатгал	5010951.00	5226529.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3948280.00	4036741.00
210204	Ажилгүйдлийн даатгал	944385.00	948825.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9443861.00	9488250.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31546467.00</b>	<b>33750867.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4177568	3427052
210302	Түлш, халаалт	17525829	18182768
210303	Цэвэр, бохир ус	9843070	12141047
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35102959.74</b>	<b>11380861.32</b>
210401	Бичиг хэрэг	193400	605500
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335200	198400
210404	Ном хэвлэл	50000	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7198580.00	1754800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13196900.00	8071390.00
210408	Бараа материал актласны зардал	14128879.74	750771.32
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>47335670.00</b>	<b>35380350.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206200.00	90700.00
210502	Хоол хүнс	46061870.00	32684590.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1067600.00	2605060.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3084200.00</b>	<b>4262900.00</b>
210604	Урсгал засвар	3084200.00	4262900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		
210702	Дотоод албан томилолт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1265500.00</b>	<b>1122800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	257500.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1008000.00	1122800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>70292187.44</b>	<b>68595865.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	609600.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4167100.00	2486500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65515487.44	66109365.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22771969.00</b>	<b>21321206.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180000.00	200000.00
<b>213</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	<b>22000133.00</b>	<b>19795733.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	<b>591836.00</b>	<b>1325473.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(29796266.18)</b>	<b>(56872167.00)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(29796266.18)</b>	<b>(56872167.00)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1131055744.00</b>	<b>980215206.49</b>	<b>(76949650.80)</b>	<b>2034321299.69</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			<b>(56872167.00)</b>	<b>(56872167.00)</b>
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1131055744.00</b>	<b>980215206.49</b>	<b>(133821817.80)</b>	<b>1977449132.69</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>692934992.00</u></b>	<b><u>683144368.00</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>692934992.00</u></b>	<b><u>683144368.00</u></b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b><u>615807600.00</u></b>	<b><u>611527900.00</u></b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	615807600.00	611527900.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b><u>1530000.00</u></b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		200000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		700000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого		630000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56630800.00	57609500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсвөөс/	56630800.00	59607500.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b><u>20496592.00</u></b>	<b><u>12476968.00</u></b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	20496592.00	12476968.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>692934992.00</u></b>	<b><u>683144368.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>692934992.00</u></b>	<b><u>683144368.00</u></b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>649666431.00</u></b>	<b><u>649346194.00</u></b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b><u>487898200.00</u></b>	<b><u>503585311.00</u></b>
210101	Үндсэн цалин	357678920.00	367647398.00
210102	Нэмэгдэл	92293598.00	96754152.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1119200.00	1201600.00
210104	Урамшуулал	36806482.00	37982161.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b><u>62052594.00</u></b>	<b><u>66746406.00</u></b>
210201	Тэтгэврийн даатгал	42705117.00	47046061.00
210202	Тэтгэмжийн даатгал	5010951.00	5226529.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3948280.00	4036741.00
210204	Ажилгүйдлийн даатгал	944385.00	948825.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9443861.00	9488250.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b><u>31546467.00</u></b>	<b><u>33750867.00</u></b>
210301	Гэрэл, цахилгаан	4177568	3427052
210302	Түлш, халаалт	17525829	18182768
210303	Цэвэр, бохир ус	9843070	12141047
210304	Байрны түрээс		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b><u>10746880.00</u></b>	<b><u>4268700.00</u></b>
210401	Бичиг хэрэг	193400.00	663000.00
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	335200.00	198400.00
210404	Ном хэвлэл	50000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7953080.00	823300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2215200.00	2584000.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>49062290.00</b>	<b>32901210.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206200.00	90700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1067600.00	2605060.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3084200.00</b>	<b>4262900.00</b>
210604	Урсгал засвар	3084200.00	4262900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		
210702	Дотоод албан томилолт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1265500.00</b>	<b>1122800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	257500.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1008000.00	1122800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4010300.00</b>	<b>2708000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	609600.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3400700.00	2708000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43268561.00</b>	<b>33798174.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20676592.00</b>	<b>12676968.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	20496592.00	12476968.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180000.00	200000.00
<b>213</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>22591969.00</b>	<b>21121206</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22000133.00	19795733.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	591836.00	1325473.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>51258.00</b>	<b>51258.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>51258.00</b>	<b>51258.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>669137400.00</b>	<b>648016194.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>669137400.00</b>	<b>648016194.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>669137400.00</b>	<b>648016194.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>503757600.00</b>	<b>503585311.00</b>
210101	Үндсэн цалин	269029300.00	367647398.00
210102	Нэмэгдэл	190844100.00	96754152.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4018200.00	1201600.00
210104	Урамшуулал	39866000.00	37982161.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66844500.00</b>	<b>66746406.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	46608800.00	47046061.00
210202	Тэтгэмжийн даатгал	5058900.00	5226529.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4047100.00	4036741.00

210204	Ажилгүйдлийн даатгал	1011800.00	948825.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10117900.00	9488250.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>53546600.00</b>	<b>33750867.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	12765600.00	3427052.00
210302	Түлш, халаалт	29582700.00	18182768.00
210303	Цэвэр, бохир ус	11198300.00	12141047.00
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3138700.00</b>	<b>3138700.00</b>
210401	Бичиг хэрэг	157800.00	33000.00
210402	Тээвэр, шатахуун		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	127800.00	198400.00
210404	Ном хэвлэл	98700.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	292600.00	323300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2461800.00	2584000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33389600.00</b>	<b>32901210.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90700.00	90700.00
210502	Хоол хүнс	30205500.00	30205450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3093400.00	2605060.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4062900.00</b>	<b>4062900.00</b>
210604	Урсгал засвар	4062900.00	4062900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		
210702	Дотоод албан томилолт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1122800.00</b>	<b>1122800.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1122800.00	1122800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3274700.00</b>	<b>2708000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2774700.00	2708000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>669137400.00</b>	<b>648016194.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>611527900.00</b>	<b>610202427.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	611527900.00	610202427.00
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>57609500.00</b>	<b>37813767.00</b>
1200041	Орон нутгийн төсвөөс	57609500.00	37813767.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>42</b>	<b>42</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	29	29
620003	Үйлчлэх ажилтан	12	12
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>360</b>	<b>360</b>

<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>		
630001	Төрийн өмчит ЕБС		
	Төрийн өмчит цэцэрлэг	360	360
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>		
	СӨБ боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮБД)	27	27
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1530,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>1530000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>1530000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		1130000.00
210401	Бичиг хэрэг		630000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		500000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		200000.00
210604	Эд хогшил, урсгал засварын зардал		200000.00
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>		200000.00
<b>213209</b>	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200000.00
		-	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 15-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 15-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Орхон аймгийн 15-р цэцэрлэг нь 2-5 насны хүүхдүүдэд СӨБ олгох үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант оны хичээлийн жилд "Хүүхэд бүрийн хөгжлийн ахиц-багш, эцэг эхчүүдийн хамтын бүтээлч үйл ажиллагаа-багшийн тасралтгүй хөгжил" зорилго дэвшүүлж, хэрэгжилтийг хангах дараах зорилт дэвшүүлсэн байна.

- Цар тахлын үед урьдчилсан сэргийлэх хариу арга хэмжээ авч, онцгой нөхцөл байдлыг даван туулах нөхцлийг бүрдүүлэн сургалт үйл ажиллагааг давагдашгүй хүчин зүйлийн үед тасралтгүй үргэлжлүүлэх, чанартай зохион байгуулах, хамтын ажиллагааны бэлэн байдлыг хангах,
- Багш бүр хүүхдийн эзэмшвэл зохих чадварын явц, үр дүнд тогтмол шинжилгээ хийж, сургалт үйл ажиллагааг бэлтгэлтэй үр дүнтэй зохион байгуулж, хүүхэд бүрт сургалтын хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмшүүлэх,
- Багш ажлын байранд тасралтгүй хөгжих, бүтээлч арга зүйг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг сонирхлын бүлэг, багаар хамтарч төлөвлөх, үр дүнг тооцох,
- Хүүхэд хамгаалалын бодлогын хэрэгжилтийг хангаж, хүүхдийг аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эцэг эхтэйгээ хамтран авч хэрэгжүүлэх
- Байгууллагын өөрийн үнэлгээг хамтын оролцоотойгоор хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, сахилга хариуцлагыг сайжруулж, дотоод хяналтыг чанаржуулах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 15-р цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 668,431.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,684.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,679.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 15-р цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,872.2 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	51.3	51.3	0.0
Бараа материал	91,951.2	85,045.9	(6,905.3)
Үндсэн хөрөнгө	1,942,318.8	1,892,351.9	(49,966.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,034,321.3</b>	<b>1,977,499.1</b>	<b>(56,872.2)</b>
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,034,321.3	1,977,449.1	(56,872.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,034,321.3</b>	<b>1,977,449.1</b>	<b>(56,872.3)</b>

Бараа материалын данс 85,045.9 мянган төгрөг болж 6,905.3 мянган төгрөгөөр буурсан нь урд онд их хэмжээний үлдэгдэлтэй байсан аж ахуйн материал болон хоол хүнсний материалуудын татан авалтыг багасгаж үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,892,351.9 мянган төгрөг болж 49,966.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын хэмжээнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,977,449.1 мянган төгрөг болж 56,872.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

15-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 42,279.0 мянган төгрөгөөр буюу 4.5 хувиар, нийт зардал өмнөх оноос 15,203.2 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар тус тус буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн 15-р цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 927,258.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 927,258.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 258,120.6 мянган төгрөгөөр бууруулан 669,137.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 258,120.6 мянган төгрөгөөр бууруулж, 669,137.4 мянган төгрөгөөр баталжээ. Хоолны зардлыг бууруулж тодотгол хийсэн байна. Мөн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, тэтгэвэрт гарах тэтгэмжийг төсвийн төслөөс хасаж төсвийг баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх СӨБ-ын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 611,527.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 57,609.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, нэмэлт санхүүжилтаар 1,530.0 мянган төгрөгөөр санхүүжиж, урсгал үйл ажиллагаанд 649,546.2 мянган төгрөгийг зарцуулж, 19,795.7 мянган төгрөгийг мянган төгрөгийг улсын төсөвт, 1,325.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 648,016.2 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 172,3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 98.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 19,795.7 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг 488.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 566.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн БОАЖГ-аас бүх нийтээр мод тарих хаврын ажлын урамшуулалд 200.0 мянган төгрөг, БСУГ-аас ариутгал халдваргүйтгэлийн зардалд 500.0 мянган төгрөг, 2021 оны багш хөтөлбөрийн шагналд 200.0 мянган төгрөг, тендер зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой орлого 630.0 мянган төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 200.0 мянган төгрөгийг 1 удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, бичиг хэргийн зардалд 630.0 мянган төгрөг, ариутгал халдваргүйтгэлийн зардалд 500.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

15-р цэцэрлэг нь 2021 онд нийт 770.6 сая төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 770.6 сая төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд 100 хувийн гүйцэтгэлтэй мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,918.7 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт, 4,578.7 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Албан шаардлага	1	4,578.7	1	4,578.7			
Зөвлөмж	2	4,918.7	2	4,918.7			
Нийт дүн	3	9,497.4	3	9,497.4			

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 31,042.5 мянган төгрөгийн материаллаг бус алдаа зөрчил илэрснээр 1 зөвлөмж өгсөн.

##### 4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа гараагүй байна.

##### 4.3 Албан шаардлага

Тайлант онд гарсан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

##### 4.3 Акт

Тайлант онд гарсан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

##### 4.4 Зөвлөмж

###### Илрүүлэлт:

Тайлант оны үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 49 нэр төрлийн 31,042.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Уг хөрөнгүүдийг ашиглагдаж байгаа, акталж устгахаар нь ангилж ялгаагүй байгаа ба УСНББОУС үндсэн хөрөнгө 17-г баримталж ажиллаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Үлдэх өртөггүй болсон хөрөнгүүдийг дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан актлаж устгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн 15-р цэцэрлэг	1	31,042.5							1	31,042.5
<b>Нийт</b>		<b>1</b>	<b>31,042.5</b>							<b>1</b>	<b>31,042.5</b>

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Ц.НАРМАНДАХ